

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/168/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2020 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	Э.Энхцэцэг
	Утас: 70523020	Цахим хаяг: enktsetseg.e@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Ц.Лүндэгмаа
		Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12	Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13	Шилэн дансны мэдээлэл	10
2.14	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3.	Менежментийн захидал	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Эзб сафт: dornogovi@audit.gov.mn

2020.02.18 № 1-6/82

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц. САРУУЛСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирагчийн ажлын албаны дарга Ц.Саруулсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.11-ээс 2020.02.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн 2/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны эрхэм зорилго нь: “Хотын захирагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хот байгуулалт, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, гадна реклам, мэдээллийн байгууламжийн талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хууль тогтоомж, бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт удирдан зохион байгуулна.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Захирагчийн ажлын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Захирагчийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшин дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 602,432.3 мянган төгрөгөөс тооцон 6,024.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны жилийн эцсийн тайлангийн цэвэр хөрөнгийн дүн 603,708.8 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 12074.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сумын захирагчийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,444.8 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	873.0	00	-873.0
Бараа материал	572,534.8	572,545.1	10.3
Үндсэн хөрөнгө	53,370.6	82,312.3	28,941.7
Хуримтлагдсан элэгдэл	-47,587.9	-51,222.1	-3,634.2
Нийт хөрөнгө	579,190.5	603,635.3	24,444.8
Өр төлбөр	00	342.4	342.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	579,190.5	603,292.9	24,102.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	579,190.5	603,635.3	24,444.8

Авлага дансны үлдэгдэл 873.0 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бичиг хэргийн материал 184.7 мянган төгрөгөөр буурч, аж ахуйн материалын үлдэгдэл 195.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 28.9 сая төгрөгөөр өссөн нь 25.0 сая төгрөгийн авто машин нэмэгдсэн, тоног төхөөрөмж дансанд 3.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл дансны буурсан зөрүү нь 3,634.2 мянган төгрөгөөр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 603.3 сая төгрөг болж 24.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн данс 24.1 сая төгрөгөөр илэрхийлэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 65,863.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төсөв батлагдсан бөгөөд нийт зардлын 65,863.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Урсгал зардалд гүйцэтгэлээр 63,000.7 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийг 2,862.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэгдсэн 2,862.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Сумын ЗДТГ-аас захиалагчийн хяналтын зардалд 31,315.8 мянган төгрөг, самбарын түрээсийн орлого 2538.0 мянган төгрөг, цахим тендерийн үйлчилгээний орлого 544.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн авлага 873.0 мянган төгрөг нийт 35271.3 мянган төгрөг орсноос 8 засварын ажилд 28563.3 мянган төгрөг, 3 байгууллагад 5141.6 мянган төгрөгийн хөрөнгө, үнэлгээний хороонд ажилласан хүмүүст ажлын хөлс, шатахуунд 1214.4 мянган төгрөг тус тус зарцуулж нийт 34919.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн ба 352.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 45,904.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 37,567.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 461.5 мянган төгрөгийн зөрчилд 1 акт, 7,876.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага бичиж алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 8,337.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Цалингийн зардлын төсвөөс ЗАА-ын 3 ажилтанд 600.0 мянган төгрөгийн түлээ нүүрс болон өвлийн хүнсний дэмжлэг /ХХОАТ-ын суутгал хийж 461.2 мянган төгрөг/ олгосон нь Сангийн сайдын 2014 оны 150 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын бүлэгт хамаарах зардлын ангилалтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. Шийдвэрлэсэн нь: Эрхзүйн актыг зөрчиж олгосон дэмжлэгийн 461.2 мянган төгрөгийг 3 ажилтнаар төлүүлж орон нутгийн төсөвт төлөх төлбөрийн акт тогтоов.

2. Хөрөнгийн тооллогыг үнэ зөв, нүдээр харж тоолоогүйгээс үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглагдахгүй болсон 3876.0 мянган төгрөгийн 2 ширхэг notebook, 4.0 сая төгрөгийн үнэ бүхий 1 ком хөгжим биетээр байхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглагдахгүй болсон, биетээр байхгүй байгаа 3876.0 мянган төгрөгийн 2 ширхэг notebook, 4.0 сая төгрөгийн үнэ бүхий 1 ком хөгжим, нийт 7876.0 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчийн тухай хуулийн дээрх заалтыг үндэслэн өмч хамгаалах Байнгын зөвлөлөөрөө дүгнэлт гаргуулан холбогдох байгууллагад саналаа хүргүүлж шийдвэрлүүлэх

3. Тусгай зориулалтын материалын дансанд 125,913.3 мянган төгрөгийн 18 нэр төрлийн ажлын зураг, төсөв, тус байгууллагын эзэмшлийн бус 450,148.5 мянган төгрөгийн 6 агаарын шугамын өргөтгөлийн ажил бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС 17-д үндсэн хөрөнгийн өртгийн бүрэлдэхүүнд “.....мэргэжлийн үйлчилгээний төлбөр” орно, Сангийн сайдын 2006 оны Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт “Барьж байгуулсан үндсэн хөрөнгийн өртөг нь барилгын материал, ажлын хөлс зэрэг холбогдох бүх зардлын дүнгээс бүрдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” зарчим, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай зориулалтын дансанд бүртгэлтэй 125.9 сая төгрөгийн зураг төсвөөс ажил нь хийгдсэн зураг төсвийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх, тухайн зураг төсвөөр ажил нь хийгдээгүй байгаа зураг төсвүүдийг хаана, хэрхэн хадгалж, бүртгүүлэх, байгууллагын эзэмшлийн бус 269.2 сая төгрөгийн 5 агаарын шугамын асуудлыг ОНӨГ-т хандан шийдвэрлүүлэх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 48 дугаар тогтоолыг үндэслэн 180.9 сая төгрөгийн агаарын шугамыг данснаас хасаж шийдвэрлэх

Аудитаар илэрсэн нэмэлт санхүүжилтийн харилцах дансны гүйлгээтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийг үнэн зөв тоолж бүртгэсэн, нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бүртгэлээ хөтөлсөн эсэхийг шалгах нь зүйтэй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага байхгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд орж ирсэн захиалагчийн хяналтын зардлаас байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж засварын ажил гүйцэтгүүлсэн. Эдгээр ажлуудад ажлыг хүлээн авсан акт, гэрээ, төсөв байхгүй байна. /Аудитын явцад баримт материалыг ирүүлсэн/

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар орж ирж буй захиалагчийн хяналтын зардлын орлого, самбарын түрээс, цахим тендерийн орлогын төсвийг ИТХ-аар батлуулж зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу ажил, гүйлгээ гарсан тухай бүр анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Захиалагчийн хяналтын зардлыг 2020 оноос манай байгууллагад шилжүүлэхийг зогсоосон. Хяналтыг аймгийн ГХБХБГ-аас тавих болсон. Анхан шатны баримтууд бүрэн байсан хэдий ч санхүүгийн баримтад хамт үдээгүй байна. Үдсэн баримтыг задалж гүйлгээний баримтуудын ард холбогдох баримтуудыг хавсаргаж архивлах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	573,407,820.00	572,545,100.00
33	АВЛАГА	873,000.00	00.00
335	Бусад авлага	873,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	873,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	572,534,820.00	572,545,100.00
351	Түүхий эд материал	567,061,800.00	567,061,800.00
35110	Тусгай зориулалттай материал	567,061,800.00	567,061,800.00
354	Хангамжийн материал	5,473,020.00	5,483,300.00
35410	Бичиг хэргийн материал	184,720.00	00.00
35420	Аж ахуйн материал	2,140,300.00	2,335,300.00
35470	Бусад хангамжийн материал	3,148,000.00	3,148,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,782,646.55	31,090,183.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,782,646.55	31,090,183.03
392	Биет хөрөнгө	5,349,313.22	31,090,183.03
39203	Авто-гээврийн хэрэгсэл	00.00	25,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,386,400.00	54,328,088.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,733,166.78	-49,509,964.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,184,200.00	2,184,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-488,120.00	-912,140.00
393	Биет бус хөрөнгө	433,333.33	00.00
39301	Програм хангамж	800,000.00	800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-366,666.67	-800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	579,190,466.55	603,635,283.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	342,355.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	342,355.00
413	Өглөг	00.00	342,355.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	342,355.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	579,190,466.55	603,292,928.03
51	Засгийн газрын хувь оролцоо	579,190,466.55	603,292,928.03
512	Хуримтлагдсан үр дүн	579,190,466.55	603,292,928.03
51210	Өмнөх үеийн үр дүн	579,190,466.55	579,190,466.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	24,102,461.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	579,190,466.55	603,635,283.03

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	625,086,856.50	130,263,728.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	576,218,156.50	64,400,728.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,746,456.50	39,400,728.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,746,456.50	39,400,728.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,723,856.50	39,400,728.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,600.00	00.00
122	Тусламжийн орлого	409,900.00	25,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	409,900.00	25,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	567,061,800.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	567,061,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,868,700.00	65,863,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,868,700.00	65,863,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,868,700.00	65,863,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	85,028,029.60	106,161,266.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,028,029.60	106,161,266.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,453,440.17	102,946,955.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,812,839.10	44,035,673.00
210101	Үндсэн цалин	37,812,839.10	42,638,670.00
210104	Урамшуулал	00.00	1,397,003.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,504,574.18	5,436,057.00
210201	Тэтгэврийн даатгал	3,006,269.45	3,856,514.00
210202	Тэтгэмжийн даатгал	378,795.94	356,719.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	288,071.74	266,403.00
210204	Ажилгүйдлийн даатгал	66,909.19	87,192.00
210205	Эрүүл мэндийн даатгал	764,527.86	869,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,484,267.29	4,555,522.90
210401	Бичиг хэрэг	1,233,380.00	1,893,920.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	1,632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	224,887.29	149,342.90
210404	Ном, хэвлэл	6,000.00	26,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,000.00	124,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	70,000.00	729,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,058,500.00	3,107,540.00
210702	Дотоод албан томилолт	1,058,500.00	1,646,640.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	1,460,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,082,166.50	11,193,838.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,082,166.50	10,977,838.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,511,093.10	34,618,324.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	29,992,173.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	992,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,511,093.10	3,634,151.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,574,589.43	3,214,311.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,574,589.43	3,214,311.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	540,058,826.90	24,102,461.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	573,618,705.92	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	573,618,705.92	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-573,618,705.92	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-33,559,879.02	24,102,461.48

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	57,592,556.50	106,136,728.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,723,856.50	40,273,728.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,723,856.50	40,273,728.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,723,856.50	40,273,728.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,723,856.50	40,273,728.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,868,700.00	65,863,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,868,700.00	65,863,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,868,700.00	65,863,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	57,592,556.50	106,136,728.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,592,556.50	106,136,728.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,017,967.07	102,922,416.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,812,839.10	43,693,318.00
210101	Үндсэн цалин	37,812,839.10	42,296,315.00
210104	Урамшуулал	00.00	1,397,003.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,504,574.18	5,436,057.00
210201	Тэтгэврийн даатгал	3,006,269.45	3,696,699.00
210202	Тэтгэмжийн даатгал	378,795.94	356,719.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	288,071.74	426,218.00
210204	Ажилгүйдлийн даатгал	74,944.19	87,192.00
210205	Эрүүл мэндийн даатгал	756,492.86	869,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,349,387.29	3,820,802.90
210401	Бичиг хэрэг	1,074,300.00	1,510,800.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	1,632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	224,887.29	221,942.90
210404	Ном, хэвлэл	30,200.00	306,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	120,000.00	150,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,058,500.00	3,107,540.00
210702	Дотоод албан томилолт	1,058,500.00	1,623,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	1,484,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,292,666.50	14,020,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,292,666.50	13,804,726.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	32,843,973.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	31,851,973.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	992,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,574,589.43	3,214,311.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,574,589.43	3,214,311.10

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	579,190,466.55	00.00	579,190,466.55
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	579,190,466.55	00.00	579,190,466.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	579,190,466.55	00.00	579,190,466.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,102,461.48	00.00	24,102,461.48
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	603,292,928.03	00.00	603,292,928.03

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,863,000.00	63,000,717.90	2,862,282.10	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,863,000.00	63,000,717.90	2,862,282.10	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,863,000.00	63,000,717.90	2,862,282.10	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,284,000.00	43,693,318.00	1,590,682.00	
210101	Үндсэн цалин	42,490,600.00	42,296,315.00	194,285.00	
210104	Урамшуулал	2,793,400.00	1,397,003.00	1,396,397.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,585,500.00	5,436,057.00	149,443.00	
210201	Тэтгэврийн даатгал	3,798,100.00	3,696,699.00	101,401.00	
210202	Тэтгэмжийн даатгал	357,500.00	356,719.00	781.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	446,800.00	426,218.00	20,582.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	89,400.00	87,192.00	2,208.00	
210205	Эрүүд мэндийн даатгал	893,700.00	869,229.00	24,471.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,870,100.00	3,820,802.90	1,049,297.10	
210401	Бичиг хэрэг	1,511,000.00	1,510,800.00	200.00	
210402	Тээвэр, шатахуун	1,632,900.00	1,632,000.00	900.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,075,800.00	221,942.90	853,857.10	
210404	Ном, хэвлэл	500,400.00	306,060.00	194,340.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00	00.00	
2107	Томиллолт, зочны зардал	3,123,400.00	3,107,540.00	15,860.00	
210702	Дотоод албан томиллолт	1,623,400.00	1,623,400.00	00.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,500,000.00	1,484,140.00	15,860.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,900,000.00	3,851,000.00	49,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,684,000.00	3,635,000.00	49,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	00.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	310,000.00	309,200.00	8,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,100,000.00	2,100,000.00	00.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	992,000.00	8,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,863,000.00	65,863,000.00	00.00	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,863,000.00	65,863,000.00	00.00	
132001	Орон нутгийн төсвөөс	65,863,000.00	65,863,000.00	00.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		05	05	00.00
620001	Удирдах ажилтан		02	02	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан		03	03	00.00
620003	Үйлчлэх ажилтан		00	00	00.00